



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 4639

Алтай хот

Г Шинэ коронавирусийн халдвартын  
болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх,  
бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/136 дугаар захирамжаар баталсан "Гамшигийн сангийн журам"-ын 3.1 дэх хэсэг, онцгой комиссын 11 дүгээр сарын 06-ны өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан гэрээнд тусгагдсан Жаргалан, Баянтоорой тосгонд гамшигаас хамгаалах иж бүрэн, Халиун, Бигэр, Эрдэнэ сумдад команд штабын дадлага сургууль зохион байгуулах зардал, Онцгой байдлын газрын автомашин, техникийн өвлийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах засвар үйлчилгээ, шинэ автомашины шатахууны зардал, Бигэр сумын боом өвчин дээр ажилласан мал эмнэлгийн үйлчилгээний зардал, Төгрөг сумын Төгрөгийн эх багийн нутагт дэвсгэрт гарсан тарваган тахлын хүний өвчлөл дээр ажилласан нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийн зардал, нийт 19781000 (арван есөн сая долоон зуун наян нэгэн мянган) төгрөгийг хавсралтад заасны дагуу аймгийн Гамшигийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Онцгой байдлын газар (З.Баттулга), Эрүүл мэндийн газар (Ц.Туяа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж, санхүүгийн баримтын бүрдлийг хангасан тохиолдолд гүйлгээг хийхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (С.Байгальмаа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг), Тамгын газрын нягтлан бодогч (Н.Наранцэцэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001769

Аймгийн Засаг даргын 2020 оны  
11. дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар  
захирамжийн хавсралт

ДЮА0042

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Товч утга	Мөнгөн дүн
1.	Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан гэрээнд тусгагдсан Жаргалан, Баянтоорой тосгонд гамшгаас хамгаалах иж бүрэн, Халиун, Бигэр, Эрдэнэ сумдад команд штабын дадлага сургууль зохион байгуулах зардал	5261000
2.	Онцгой байдлын газрын автомашин, техникийн өвлийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах засвар үйлчилгээ, шинэ автомашины шатахууны зардал.	5500000
3.	Бигэр сумын боом өвчин дээр ажилласан мал эмнэлгийн үйлчилгээний зардал.	6570000
4.	Төгрөг сумын Төгрөгийн эх багийн нутагт дэвсгэрт гарсан тарваган тахлын хүний өвчлөл дээр ажилласан нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийн зардал	2450000
	Дүн	19781000

—ооо—